

Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтын мэдээлэл

А. 2021-2022 хичээлийн жилд боловсрол нөхөн эзэмшихээр бага боловсролд -10, суурь боловсролд -26, бүрэн дунд боловсролд -77, нийт 113 суралцагч суралцаж байна. Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй-5, хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхэд, суурь боловсролд 3, бага боловсролд 3 нийт 6 лам хүүхэд суралцаж төгссөн.




График № 1, 2 Суралцагчдын нас хүйс



График № 3, 4 Сурагчдын ангийн тоо, боловсролын түвшин

- Боловсрол нөхөн олгох ангид 25 суралцагч танхимаар, бие даах гэсэн хэлбэрээр явагдсан. Сургалтын орчноо сайжруулж, анги танхимдаа 130.000 төгрөгний тохижилт хийсэн.
- Боловсрол нөхөн олгох ангид Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/88 дугаар тушаалаар батлагдсан “Боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр”-өөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтыг үр дүнтэй зохион байгуулан, хичээл судлагдахууныг Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багш нараар заалгах НТБТ-ийн захирлын албан тоотыг үндэслэн, багш нарын ажлын ачааллыг бууруулан ЕБС-ийн мэргэжлийн багш нараар хичээл судлагдахууныг заалгасан учраас хавсран ажилладаг багш байхгүй болно.
- Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвийн суралцагчид багш нар болон эцэг эхчүүддээ “АВЪЯАСАА ГЭРЭЛТҮҮЛЬЕ” тайлан тоглолтоо хийлээ.
- Дүүргийн Спорт хорооны дэргэдэх жудогийн секцэд 4, гар бөмбөгийн секцэд 4 сурагч хамрагдаж, дүүргийн уралдаан тэмцээнд оролцон амжилт гаргаж байна.

В. 2022-2023 оны хичээлийн жилд эрэгтэй 60, эмэгтэй 30 нийт 90 суралцагч суралцаж байна.



График № 5 Хүйсээр нь авч үзвэл



График № 6 Насны ангиллаар авч үзвэл



График № 7 Суралцах хэлбэрийн хувьд танхимаар 25, танхимын бус зайнаас 65 суралцагч байна.

Энэ хичээлийн жилд бага боловсролын 4-р ангид 3, 5-р ангид- 5 нийт 8 суралцагч, суурь боловсролд 6-р ангид -4, 7-р ангид -2, 8-р ангид 3, 9-р ангид 11 суралцагч, бүрэн дунд боловсрол эзэмшихээр 10- ангид 11, 11-р ангид 9, 12-ангид 42 иргэн суралцаж эхэллээ.



График № 8 Суралцаж буй түвшин

Дүгнэлт:

- Энэ хичээлийн жилд бага болон суурь боловсролд суралцагчдын тоо бага, бүрэн дунд боловсрол эзэмших иргэдийн тоо их байв.
- ЕБС руу 2 сурагч шилжсэн суралцсан. 9-р ангийн суралцагч З.Занданшатар СХД-ийн ЕБ-ын 156 дугаар сургуульд, 11-р ангиас С.Отгонтуяа Увс аймгийн Хяргас сумын ЕБС руу тус тус шилжин суралцлаа.
- Боловсролын гэрчилгээ болон үнэмлэх авахад гарсан хүндрэлгүй.
- Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулбал НБГ, БШУЯ суралцах хүсэлт гаргасан иргэдийг бичиг баримт бүрэн тохиолдолд баталгаажуулах явц чирэгдэлгүй байлаа.